



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Төслийн удирдах хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт, үнэлэх журам”-ын 10.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан Зээл болон буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Удирдах хорооны үйл ажиллагааг зохион байгуулж, төслийн үйл ажиллагааг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй уялдуулан удирдлагаар хангаж ажиллахыг төслийн Удирдах хороо /С.Мөнгөнчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
Сайдын 2018 оны 09 дугаар сарын 03
-ны өрдийн 125 тоот тушаалын
хавсралт



**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ,
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”- ИЙН УДИРДАХ ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд
- Гишүүд: Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга
- Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга
- Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга
- Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга
- Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх
- Төрийн бус байгууллагын төлөөлөл – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо
- Төрийн бус байгууллагын төлөөлөл – Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв
- Нарийн бичгийн дарга Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч